



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/441

Зуунмод

Хамгаалах арга хэмжээгээр газар
эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 56 дугаар зүйлийн 56.4, 56.6, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Голын ай сав, урсацыг сайжруулах ойр орчмыг хамгаалах зорилгоор газар эзэмшихээр өргөдөл ирүүлсэн “Этэрнал инфинити” ХХК (6123562)-д Баруун Зуунмод /6-р/ багийн “Комир Эм Жи Эл” компанийн зүүн талд Мод үржүүлгийн зориулалттай (19752м²) газрыг хуулийн дагуу 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч “Этэрнал инфинити” ХХК-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг хийлгэж, Мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Эзэмшиж байгаа газрынхаа эргэн тойронд (50-аас доошгүй метрийн)-ийн доторх хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, орчноо цэвэр ариун байлгах арга хэмжээ авах.

3. Газрын даамал (Г.Баярсайхан)-д дараах ажил үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын төлбөрийг хугацаанд нь төсөвт оруулах.

3.3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

